

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 13

Хуралдаан 2013 оны тавдугаар сарын 2-ны өдрийн 14 цаг 05 минутад эхэлж, 14 цаг 59 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 54 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны зарим газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p> <ul style="list-style-type: none">-Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга-Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга-Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны зарим газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, дүнг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны саналын дагуу хойшлуулахаар шийдвэрлэв.</p>
2	<p>Хууль зүйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны тавдугаар сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Дугарын Сүнжид, Гончигдашийн Сувдаа нарыг Хууль зүйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны

		<p>удирдах ажилтны нөөцөд бүртгэх</p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан иргэдээс Дугарын Сүнжидийг Хууль зүйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлөөс зохион байгуулсан Эрүүл мэндийн яамны харьяа тусгай мэргэжлийн үндэсний лавлагаа төвүүдийн төсвийн ерөнхий менежер, захирлуудын сонгон шалгаруулалтын талаар гаргасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.12, “Комисс томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн даргын 2013.04.26-ны өдрийн 47 дугаар тушаалаар байгуулагдсан комиссын дүгнэлт болон Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. “Хүсэлт хүргүүлэх тухай” Эрүүл мэндийн сайд Н.Удвалын 2013 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 1а/1509 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд ирүүлсэн Тагнуулын ерөнхий газар болон нийслэлийн Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн I хэлтсийн нэрийг барьсан нэгэн иргэн сонгон шалгаруулалтын комиссын гишүүдийг дарамталсан, үйл ажиллагаанд нь нөлөөлөхийг оролдсон үйлдлийг шалгуулах хүсэлтийг холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.</p> <p>2. Лхамсүрэнгийн Жамбалжав нь 1949 оны 12 дугаар сарын 05-ны өдөр төрсөн бөгөөд сар бүр өндөр настны тэтгэвэр авч байгаа, Хөдлөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалтыг баримтлан холбогдох баримт бичгээр нотлогдож байх тул түүний сонгон шалгаруулалтийн бүртгэл, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд томилогдох ажилтны нөөцөд бүртгэснийг тус тус хүчингүй болгохыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны</p>

	<p>зөвлөлийн салбар зөвлөлд үүрэг болгох.</p> <p>3. Ойдовын Баатархүү нь тухайн өрсөлдсөн Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирлын ажлын байрны шаардлагын “Эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд 5 ба түүнээс дээш жил ажилласан” байх шаардлагыг хангахгүй байх тул түүнийг төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд томилогдох ажилтны нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлсэнийг хүчингүй болгож, уг албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын шинээр зохион байгуулахыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд үүрэг болгох.</p> <p>4. “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам” батлах тухай Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 60 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу Улсын гуравдугаар төв эмнэлгийн даргын албан тушаалд өрсөлдсөн Ц.Энхбаяр, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн даргын албан тушаалд өрсөлдсөн С.Туул, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн даргын албан тушаалд өрсөлдсөн Н.Гансүх нарын гомдлыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд шилжүүлж 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор шийдвэрлэхийг үүрэг болгох.</p> <p>5. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд тус яамны зохион байгуулалтын нэгжийн удирдах албан тушаалтан нарын түр орлон гүйцэтгэгчийн томилгоог 2013 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохих ёсоор шийдвэрлэхийг үүрэг болгох.</p> <p>6. Энэхүү тогтоолын гүйцэтгэлд хяналт тавьж, биелэлтийг ханган Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг комиссын дарга /Д.Даваа-Очир/-д даалгх тухай Монгол Улсын</p>
--	--

		төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
4	Бусад асуудал - Сонгон шалгаруулалт хойшлуулах тухай	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн "Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай" 2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 3179 дугаар захирамжаар Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн өмчийн хорооны даргын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулахгүй байхыг даалгасан тул Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд байршуулсан сонгон шалгаруулалтын зарыг буцаан татахаар шийдвэрлэв.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ